

САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ журмаар хувьцаат компани кумулятив аргаар төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэх тохиолдолд энэхүү журмыг баримтлана.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОХ

2.1.Кумулятив аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох ердийн болон хараатбус гишүүдийн нийт тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаанд ногдох энэ санал нь ТУЗ-д эзлэх ердийн болон хараат бус гишүүний эзлэх хувьд хуваагдана.

2.2.Энэ журмын 2.1-т заасан саналаа хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд эзлэх хувьд хуваагдсан хэмжээнд бүгдийг нь нэг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид, эсхүл хэд хэдэн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

2.3.Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно. Жишээ нь: хувьцаа эзэмшигч А нь “Б” ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн ньхараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэгэнгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээрсонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээрсонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.

2.4.Кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо энэхүү журмын 2.1, 2.2, 2.3-таасан журмыг зөрчсөн бол сонгуулын дүнг хүчингүйд тооцно.